

# “ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 он 03 сар 02 өдөр

Дугаар: 17/03/02

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.1, 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 04-р сарын 14-ний өдрийн 12 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Олимпийн гудамж, Реженси Резиденс байр 3-р давхарт 314 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 03-р сарын 24-ний өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэцүүлэхээр баталсугай. Үүнд:
  1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
  2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөл төлөвлөгөөг батлах
  3. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
  4. Бусад.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2017 оны 03 дугаар сарын 06-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2017 оны 03-р сарын 23-нд уг зарыг дахин давтан, 2017 оны 03-р сарын 10-ны дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2017 оны 04-р сарын 14-ний өдрийн 11 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2017 оны 03-р сарын 06 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Г.Оюунболд/-т даалгасугай.

8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх Захирал Г.Оюунболдыг, гишүүнээр Бизнес хөгжлийн менежер, шинжээч Э.Саранчимэгийг Тооллогын комиссийн даргаар ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн Б.Өлзийбаярыг, гишүүнээр ТУЗ-ийн гишүүн Г.Халиунааг тус тус томилсугай.
10. “Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



**Б.ОТГОНТУЯА**